



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛС, БҮГД
 НАЙРАМДАХ КУБА УЛСЫН ХООРОНД ШУУДАН,
 ЦАХИЛГААН ХОЛБОО ТОГТООХ ТУХАЙ
 Х Э Л Э Л Ц Э Э Р

Бүгд Найрэмдах Монгол Ард Улсын Засгийн гэээр,
 Бүгд Найрэмдах Куба Улсын Засгийн гэээр,

Хоёр орны хоорондын улс төр, эдийн засаг, соёлын харилцааг цээнид хөгжүүлэх явдалд тус дөхөм үзүүлэх эрмэлзлийг удирдлага болгож, дээрх зорилтыг биелүүлэхэд хоёр Этгээдийн хооронд шуудан, цахилгаан холбооны хөмтэн ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх явдал дээр дурдсан зорилгыг биелүүлэхэд тус хүргэнэ гэж үзээд,

энэхүү Хэлэлцээрийг бэйгуулахаар шийдэж бүрэн эрхт төлөөлөгчдөөрөө:

Бүгд Найрэмдах Монгол Ард Улсын Засгийн гэээр Бүгд Найрэмдах Монгол Ард Улсын Холбооны Яамны сайд ДАХЫН ГОТОВ,

Бүгд Найрэмдах Куба Улсын Засгийн гэээр Бүгд Найрэмдах Куба Улсаас Бүгд Найрэмдах Монгол Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд ГУСТАВО МАССОРА ЭРНАНДЕС

нэрыг тус тус томилсноор тэд зохих ёс журмын дагуу үйлдсэн бүрэн эрхийн үнэмлэхээ харилцан солилцож дэрээх зүйлүүдийн талаар хэлэлцэн тохиролцов.

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Нэгдүгээр зүйл

Бүгд Найрэмдах Монгол Ард Улс, Бүгд Найрэмдах Куба Улс нь дундын орноор дамжуулан хоёр орны хооронд энгийн ба баталгаатай бичиг захидал, шуудангийн энгийн илгээлт, ном, сонин хэвлэл мөн түүнчлэн төрөл бүрийн цахилгаан мэдээ, телефон яриаг байнга харилцан солилцож бэйхаар тогтов.



2.

Хоёрдугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч нэг Этгээд нь нөгөө Этгээдийн бичиг захидал, шуудангийн илгээлт, цахилгаан мэдээ, телефон ярианы төрлүүдийг гурав дахь оронд дэмжуулахад өөрийн байгууллагын шуудан ба цахилгаан холбооны зам, чиглэлийг ашиглаж байна.

2. Хоёр Этгээд нь бичиг захидал, шуудангийн илгээлт, цахилгаан мэдээ, телефоны яриаг бусад оронд явуулахад ашиглаж бэйгээ шуудан, цахилгаан холбооны зам, чиглэлийг харилцан бие биедээ мэдээлэх болно.

Гуравдугаар зүйл

Хоёр Этгээд болон тэдгээрийн шуудан, цахилгаан холбооны байгууллагууд нь элбэныхээ харилцаанд франц, орос, англи хэлийг хэрэглэнэ.

Эцсийн станцуудын ажилчид нь ажилдаа франц, орос, англи хэлийг ашиглана.

Дөрөвдүгээр зүйл

Шуудангийн бүх төрлийн-солилцоо, цахилгаан мэдээ, телефон яриаг солилцох төвүүд нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсын талаас Улаанбаатар хот, Бүгд Найрамдах Куба Улсын талаас Гавана хот байх болно.

Тавдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Этгээдүүдийн шуудангийн байгууллагуудаас солилцооны их, багыг хөргөлзэн тогтоосон солилцох газрын боодлоор /депеш/ бичиг захидал, бэлэг илгээлтийг солилцох байна.



3.

Бичиг захидал, бэлэг илгээлтийг түргэн дамжуулах явдлыг хангах бололцоотой гэж үзвэл бусад оронд дамжуулах зүйлийг Хэлэлцэн тохирогч Этгээдүүдийн хоорондын шууд харилцаанд хэрэглэх боодол дотор хийж задгай явуулж болно.

Зургадугаар зүйл

Хоёр Этгээдийн холбооны байгууллагууд, тэдгээрийн гүйцэтгэх газруудын хооронд солилцох бүх бичиг захидал нь хурзамжаас чөлөөлөгдөх бөгөөд мөн шуудан, цахилгаан мэдээ, телефон холбооны асуудлаар элбэны цахилгаан мэдээ, телефон яриу нь үнэ төлбөргүй явагдана.

Долдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Этгээдүүд нь дийлж давагдашгүй хүчний улмаас гэмтсэн буюу үрэгдсэн шуудангийн явуулалтад хариуцлага хүлээхгүй болно.

Ниймдугаар зүйл

1.Хэлэлцэн тохирогч Этгээдүүдийн шуудангийн байгууллагууд нь дотоодын ба олон улсын шуудан, цахилгаан холбооны талаарх бүх төрлийн хэвлэл, мэдээлэл солилцож байх болно.

2.Хэлэлцэн тохирогч Этгээдүүд нь шууд ба дамжуулах шуудангийн солилцоогоор өөрсдийн оронд оруулахыг хориглосон бараа товартай холбогдсон хориглолт, хязгаарлалтын талаар харилцан бие биедээ мэдээлж байна.

Есдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч Этгээдүүд нь өөрсдийн байгууллагуудад бичиг захидал, бэлэг илгээлт солилцох ба дамжуулж явуулахад Хэлэлцэн тохирогч Этгээдүүдийн шуудангуудыг харилцан ашиглаж байхыг зөвшөөрнө.



Т О О Ц С О

Арван нэгдүгээр зүйл

1. Шуудан, цахилгаан холбооны солилцооны харилцан хийх тооцоо нь мөрдөгдөж бэйгээ Дэлхийн шуудангийн холбооны Конвенц, Олон улсын цахилгаан холбооны Конвенцээр бөтлөгдсөн алтан франкийн үндсэн дээр хийгдэнэ.

2. Шуудан, цахилгаан холбооны солилцоо, шуудангийн агаарын тээврийн зөвдлын тооцоог харилцан хийх хугацааг Хэлэлцэн тохирогч Этгээдүүдийн холбогдох байгууллагуудын хэлэлцэн тохиролцооноор тогтооно.

ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

Арван хоёрдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч Этгээдүүдийн холбооны байгууллагууд шуудан, телефон, телеграфын холбооны ашиглалтыг зохион байгуулах ажилд хэлэлцэн тохирогч талуудын нэгдэн орсон Дэлхийн шуудангийн холбоо, Олон улсын цахилгаан холбооны Конвенц, гэрээ хэлэлцээрүүд, регламентыг хэрэглэх болно.

Арван гурвдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрт нарийн тодорхойлогдоогүй асуудлыг Дэлхийн шуудангийн холбоо, Олон улсын цахилгаан холбооны Конвенциудын заалтын дагуу зохицуулж байх болно.

Арван дөрөвдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрт Хэлэлцэн тохирогч Этгээдүүд харилцан зөвшөөрөлцсөний үндсэн дээр нэмэлт өөрчлөлт оруулж болно.



Арван тэвдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээр нь хугацаагүй байгуулагдаж байгаа бөгөөд гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

Арван зургадугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Этгээдүүд нь энэхүү Хэлэлцээрийг цуцалж болох бөгөөд Хэлэлцэн тохирогч нэг Этгээдээс нөгөөдөө цуцлах тухай мэдэгдсэнээс 6 сарын дараа Хэлэлцээр хүчингүй болсонд тооцогдоно.

Энэхүү Хэлэлцээрийг 1970 оны II дүгээр сарын 27 -ны өдөр Улаанбаатар хотноо монгол, испани, орос хэл дээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд хоёр эх нь адил хүчинтэй болно.

Хэлэлцээрийг тайлбарлахад зөрөө гарвал орос хэл дээрх эхийг баримтлана.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЭРХ
ОЛГОСНООР

БҮГД НАЙРАМДАХ МУЗЫКАЛЬСКИЙ
ЗАСГИЙН ГАЗРЫН ЭРХ ОЛГОСНООР